

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ 07 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 07 дугаар хуралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 15 цаг 08 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 76.9 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Монгол Улсын Төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцүүлэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган, сайжруулж, холбогдох яамдад болон нэгтгэлийг Сангийн яаманд хүргүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярсүх, мэргэжилтэн Л.Батгэрэл нарт үүрэг болгов.
2	Аймгийн орон нутгийн замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах журам	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн орон нутгийн замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах журмын төслийг хэлэлцүүлэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган, тоо баримтыг дахин нягтлан хянаж, холбогдох хэлтэс, тасгуудаас санал авч 06 дугаар сард зохион байгуулах аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгохыг Жаргалант сумын Засаг дарга Ч.Цогтбаяр, Санхүү албаны дарга О.Сэрчмаа нарт үүрэг болгов.
3	Биеийн тамир, спортын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Биеийн тамир, спортын газрын бүтэц орон тоог батлах тухай асуудлыг хэлэлцүүлэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган, бүтэц орон тоог батлуулахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадорж, Биеийн тамир, спортын газрын дарга Ч.Түмэндэмбэрэл нарт үүрэг болгов.
4	"Хотоо цэвэрлэж, модоо тарья" аян зохион байгуулах асуудлыг хэлэлцүүлэх тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 01-нийг хүртэл "Хотоо цэвэрлэж, модоо тарья" аяныг хариуцан зохион байгуулахыг Д.Энхболд даргад үүрэг болгов.
	"Эхийн алдар" нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн материал хэлэлцүүлэх тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн хүрээнд 17 сумаас ирүүлсэн "Эхийн алдар" нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн материалыг дахин сайтар нягтлан хянаж, холбогдох заавар, журмын дагуу архивын баримт бүрдүүлэн, жагсаалтаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Төрийн

		захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Гантөмөр нарт тус тус үүрэг болгов.
--	--	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР